

БАТЛАВ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА


Д. ТӨМӨРБААТАР

2023 оны 09 сарын 27 өдөр


СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажлын зорилго үндэслэл,	<p>Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба "Алсын хараа-2050" хөгжлийн бодлого, Нийслэл, дүүргийн хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлын хэмжээг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг.</p> <p>Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр хог хаягдлын хэмжээ жил бүр нэмэгдэхийн зэрэгцээ төрөл, бүтцийн хувьд ч өөрчлөгдөх болсон. Тухайлбал, сүүлийн 10 жилийн хугацаанд хог хаягдлын үүсэх хэмжээ 3 дахин нэмэгджээ. Үүнээс төмөр металлын хаягдлыг оруулалгүйгээр ердөө 4.4 хувийг нь дахин ашиглаж 95,6 хувийг төвлөрсөн цэгүүдэд дарж устгасан байна.</p> <p>СХД-ийн хог хаягдлын менежментийг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, хөрсний доройтлоос хамгаалах, оршин суугч иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор гэр болон орон сууцны хороодын оршин суугч иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, хог хаягдалтай зүй зохистой хаях дадал, хэвшлийг бий болгох, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах менежмент, үйлчилгээний хураамж, санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.</p>
2	Хамрах хүрээ	<p>Сонгино хайрхан дүүргийн Толгойт бүсийн 14 хороо, Өнөр бүсийн 9 хороо, Баянхошуу бүсийн 13 хороо, Төвийн бүсийн 7 хороо, нийт 43 хорооны айл өрх, иргэд, аж ахуй нэгж, байгууллага хамрагдана.</p>


3	Ажил гүйцэтгэх хугацаа	Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлыг гэрээ байгуулж, урьчилгаа төлбөр орсон өдрөөс эхлэн 30 хоногт багтаан хийж, тайлан, гарын авлага, тараах материал, видео контентийг хүлээлгэн өгсөн байна.
4	Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
5	Хийгдэх ажил	<p>Дүүргийн гэр болон орон сууцны хорооны иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад дараах сэдвээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлага, илтгэл, зөвлөмж боловсруулж, сургалтыг зохион байгуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын хууль эрх зүйн орчин, иргэд, ААНБ хүлээх үүрэг, хариуцлага • Гэр хороо болон орон сууцны хороонд амьдардаг айл, өрх ААНБ-ын онцлогт тохирсон хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах үйл ажиллагаа • Хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах санаачлага, туршлага • Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга хэмжээ • Хог хаягдлын санхүүгийн менежмент, үйлчилгээний хураамж, төлбөр <p>Сургалтанд хамрагдах иргэд, ААНБ тоо:</p> <ul style="list-style-type: none"> • Сонгино хайрхан дүүргийн Толгойт бүсийн 14 хороо, Өнөр бүсийн 9 хороо, Баянхошуу бүсийн 13 хороо, Төвийн бүсийн 7 хороо, нийт 43 хорооны айл өрх, иргэд, аж ахуй нэгж байгууллагад сургалт хийх. Нэг хороонд 50-аас доошгүй иргэд, 10 доошгүй ААНБ танхимын сургалтанд хамруулах <p>Сургалтанд шаардлагатай гарын авлага, тараах материал</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлыг хог хаягдлын хууль эрх зүйн орчин, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, зориулалтын уут сав хэрэглэх, зүй зохистой хаях дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн гарын авлагын эх загварыг боловсруулах, 1000 доошгүй ширхэгийг хэвлэж, тараах. Гарын авлагын хэмжээ А5 хэмжээтэй, өнгөт, багадаа 4 нүүр байна. • Хог хаягдлын улмаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж буй хор хохирол, сөрөг нөлөөллийн талаар гарын авлагын эх загвар бэлтгэх, 1000 доошгүй ширхэгийг хэвлэж тараах, Гарын авлагын хэмжээ А5 хэмжээтэй 4 нүүр байна. • Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, зүй зохистой хаях дадал, хэвшлийг бий болгох 10-20 секундын видео шторк бэлтгэх


		<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын хууль, тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага талаар контент бэлтгэх • Сургалтанд оролцогчдыг бичгийн хэрэгсэл болон бусад тараах материал, үзүүлэн, гарын авлагаар хангах
6	Нэмэлт ажил	<p>Зөвлөх компани нь өөрсдийн санаачлагаар дараах ажлыг нэмэлтээр хийж болох бөгөөд үүнийг сонгон шалгаруулалтад харгалзан үзнэ.</p> <ul style="list-style-type: none"> • СХД-ийн хог хаягдлын олон нийтэд зориулсан брендинг бий болгох / лого, маскот, уриалга/ • СХД-ийн хог хаягдлын менежментийн сургалт, олон нийттэй харилцах стратеги боловсруулах
7	Зөвлөх компанид тавигдах шаардлага	<p>Зөвлөх компани нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулсан 5 доошгүй жилийн туршлагатай байх • Сургалт зохион байгуулах техник, хэрэгсэл, тоног төхөөрмжтэй байх • Хог хаягдлын чиглэлээр судалгааны ажил, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлагатай байх • Байгаль орчин, хог хаягдлын менежментээр мэргэшсэн ажилтан, албан хаагчтай байх
8	Зөвлөх багт тавигдах шаардлага	<p>Зөвлөх баг нь дараах бүрэлдэхүүнтэй байна:</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөх багийн ахлагч: Хог хаягдлын менежментийн чиглэлээр төр, захиргааны байгууллага болон гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт 15 доошгүй жил ажилласан туршлагатай байх • Хог хаягдлын менежментийн зөвлөх: Байгаль орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр төрийн болон хувийн хэвшил, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, • Хууль, эрхзүйч. Байгаль орчин, хог хаягдлын менежментийн хууль эрхзүйн чиглэлээр олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрт ажиллаж байсан, доод тал нь 10 жилийн ажлын туршлагатай байх • Туслах ажилтан 3-аас доошгүй байх ба тэдгээр нь байгаль орчин, хог хаягдлын чиглэлээр доод тал нь 2 жил ажилласан, олон нийтийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, видео контент бэлтгэх өндөр чадвартай байх,
9	Тендерийн бичигт материал баримт ирүүлэх	<ul style="list-style-type: none"> • Компаний гэрчилгээ, танилцуулга, хог хаягдлын менежментийн чиглэлээр хийсэн ажлын жагсаалт • Зөвлөх багийн гишүүд тус бүрийн танилцуулга /CV/ • Сургалтын хуваарь, график, төлөвлөгөө • Сургалтын агуулга, сэдэв, илтгэл • Гарын авлага, тараах материалын загвар
10	Төсөв тооцох	<p>Санал болгох үнийн дүнд зөвлөх багийн гүшүүдийн цалин, томилолт, татвар нийгмийн даатгал, тээврийн зардал, гарын авлага тараах материалын эх бэлтгэл,</p>

	хэвлэл, видео шторк, контентийн эх бэлтгэх, олон нийтийн сүлжээгээр цацах зардал, тоног төхөөрөмжийн түрээс, үдийн цай, сургалтанд оролцогчдод зориулсан бичгийн хэрэгсэл, дэвтэр, сургалтын материалуудын зардлыг тооцно.
--	--



ХЯНАСАН:

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ТАСГИЙН
ДАРГА  Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН 

С.УРАНЧИМЭГ